



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/395

Хэрлэн сум

Хөдөлмөр зуслангийн хувилбарт үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.4.9.1 дэх заалтын хүрээнд Хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан “Хөдөлмөр зуслангийн хувилбарт үйлчилгээг сум тус бүр өөрийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх” ажлыг зохион байгуулахад 5,000,000 (таван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Хүүхдэд ээлтэй орон нутаг болно зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баярбаатар)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ